



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2025 оны 03 сарын 20 өдөр

Дугаар 13.1

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг сунгах,
үнийг шинэчлэн тогтоох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсгийн 2 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 7.1, 7.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Дотоод хэргийн их сургуулийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч цаашид ашиглаж болох 15 нэрийн, нийт 354,458,039.15 (гурван зуун тавин дөрвөн сая дөрвөн зуун тавин найман мянга гучин есөн төгрөг арван таван мөнгө) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, нийт үнийг 269,322,606.00 (хоёр зуун жаран есөн сая гурван зуун хорин хоёр мянга зургаан зуун зургаа) төгрөгөөр хавсралтад заасны дагуу шинэчлэн тогтоохыг зөвшөөрсүгэй.

2.Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар, Дотоод хэргийн их сургуулийн захирал, бригадын генерал П.Батбаатар нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгийн ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоох ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, удирдлага, зохицуулалтын цахим систем"-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2025 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТЭСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ

133000307
7-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2025 оны 05 дугаар сарын 24-ны өдрийн
131... дугаар тогтоолын хавсралт

ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, АШИГЛАХ ХУГАЦААГ СУНГАХ ҮНИЙГ ШИНЭЧЛЭН ТОГТООХ
ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Үндсэн хөрөнгийн нэр, марк	Ашиглалтад орсон огноо	Хэм жих нэгж	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Тоо хэм жээ	Балансын нийт үнэ, хуриутлагдсан элэгдэл (төгрөг)	Цаашид ашиглах жил (жилээр)	Шинэчлэн тогтоох үнэ нэг бүрийн үнэ (төгрөг)	Шинэчлэн тогтоох балансын нийт үнэ (төгрөг)
1	Гадна төв хашаа /Их сургуулийн төв байр/	8/1/1978	ш	55,770,000.00	1	55,770,000.00	15	11,717,849.00	11,717,849.00
2	Хашаан доторх бохир усны шугам /ХАС/	1/1/1978	ш	33,354,000.00	1	33,354,000.00	10	21,258,900.00	21,258,900.00
3	Халуун усны байр /Гүнжийн хоолой/	8/29/2014	ш	7,934,000.00	1	7,934,000.00	30	27,000,101.00	27,000,101.00
4	Цахилгааны трансформатор /Гүнжийн хоолой/	11/28/2014	ш	53,357,929.15	1	53,357,929.15	10	38,725,800.00	38,725,800.00
5	Бохир усны гадна шугам /АМСҮТ/	1/1/1978	ш	17,824,000.00	1	17,824,000.00	10	20,950,800.00	20,950,800.00
6	Контейнер /Гал тогоо/	6/30/2015	ш	10,500,000.00	2	21,000,000.00	11	10,798,225.50	21,596,451.00
7	Контейнер /Сонсогчийн байр/	8/28/2015	ш	18,000,000.00	2	36,000,000.00	11	10,798,225.50	21,596,451.00
8	Контейнер /Удирдлагын төв байр хүн эмнэлэг/	12/31/2014	ш	3,914,000.00	1	3,914,000.00	11	6,008,690.00	6,008,690.00
9	Контейнер /Гал тогоо/	12/31/2014	ш	4,000,000.00	1	4,000,000.00	11	6,008,690.00	6,008,690.00
10	5 ханатай иж бүрэн гэр	11/2/2015	ш	15,640,000.00	1	15,640,000.00	6	1,800,000.00	1,800,000.00
11	Контейнер /Сонсогчийн байр/	6/30/2017	ш	14,408,080.00	5	72,040,400.00	13	12,761,539.00	63,807,695.00
12	Агуулах Контейнер 40 тн ГХ/	8/30/2017	ш	3,500,000.00	1	3,500,000.00	13	7,101,179.00	7,101,179.00
13	Худаг /Гүнжийн хоолой/	9/29/2017	ш	9,900,000.00	1	9,900,000.00	2	12,000,000.00	12,000,000.00
14	Агаар сорох систем /Их сургуулийн төв байр В1/	12/31/2018	ш	2,022,371.00	5	10,111,855.00	5	975,000.00	4,875,000.00
15	Агаар оруулах систем /Их сургуулийн төв байр В1/	12/31/2018	ш	2,022,371.00	5	10,111,855.00	5	975,000.00	4,875,000.00

Д/д	Үндсэн хөрөнгийн нэр, марк	Ашиглалтад орсон огноо	Хэм жих нэгж	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Тоо хэм жээ	Балансын нийт үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Цаашид ашиглах жил (жилээр)	Шинэчлэн тогтоох үнэ нэг бүрийн үнэ (төгрөг)	Шинэчлэн тогтоох балансын нийт үнэ (төгрөг)
15	Нийт					354,458,039.15 (гурван зуун тавин дөрвөн сая дөрвөн зуун тавин найман мянга гучин есөн төгрөг арван таван мөнгө)			269,322,606.00 (хоёр зуун жаран есөн сая гурван зуун хорин хоёр мянга зургаан зуун зургаан төгрөг)